

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 337

АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	2
337.1 Зорилго	2
337.3 Ачаа тээвэр зуучлалын байгууллагын гэрчилгээ	2
337.5 Өргөдөл гаргах.....	2
337.7 Гэрчилгээ олгох.....	2
337.9 Гэрчилгээний хугацаа	2
337.11 Гэрчилгээг шинэчлэх, сунгах.....	3
337.13 Аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалт.....	3
Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	3
337.51 Ажилтан, албан тушаалтанд тавигдах шаардлага	3
337.53 Хангалт, хэрэгсэл	3
337.55 Бичиг баримт	3
337.57 Тайлан, мэдээ	3
337.59 Чанарын дотоод хяналтын систем.....	4
337.61 Байгууллагын зааварт тавигдах шаардлага.....	5
В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА.....	5
337.101 Гэрчилгээ эзэмшигчийн үндсэн үүрэг	5
337.103 Байгууллагын зааварт өөрчлөлт оруулах.....	5
Г БҮЛЭГ. АГААРААР АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТҮР ГЭРЧИЛГЭЭ	6
337.151 Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлага	6
337.153 Үндсэн үүрэг.....	6
337.155 Тайлан, мэдээ	6

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын
2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар
тушаалын 25 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮҮРЭМ -337

АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

337.1 Зорилго

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх байгууллагыг гэрчилгээжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.

337.3 Ачаа тээвэр зуучлалын байгууллагын гэрчилгээ

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх байгууллагын зохион байгуулалтаас хамаарч дараах төрлийн гэрчилгээг олгоно:

- 1/ Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх гэрчилгээ;
- 2/ Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх түр /хязгаарлагдмал нөхцөлтэй/ гэрчилгээ.

337.5 Өргөдөл гаргах

(а) Энэ дүрмийн дагуу агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч /цаашид Өргөдөл гаргагч гэх/ нь ИНЕГ-0337/01 маягтыг бөглөж дараах бичиг баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид ИНЕГ гэх/-т ирүүлнэ:

- 1/ ачаа тээвэр үйлчилгээний заавар;
- 2/ аюултай ачаа тээвэрлэх заавар;
- 3/ аюултай ачаа тээвэрлэх сургалтын хөтөлбөр;
- 4/ нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр;
- 5/ төлбөрийн баримт.

337.7 Гэрчилгээ олгох

(а) Энэ дүрмийн шаардлагыг хангасан Өргөдөл гаргагчид ИНЕГ-аас Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх гэрчилгээ олгоно.

337.9 Гэрчилгээний хугацаа

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх гэрчилгээг 2 жил хүртэл хугацаатай олгоно.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ олгогдсоноос хойш нэг жилийн дотор агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлээгүй бол гэрчилгээг хүчингүйд тооцно.

337.11 Гэрчилгээг шинэчлэх, сунгах

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, эсхүл ИНЕГ-аас үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоох хүртэл хүчин төгөлдөр байна.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг шинэчлэх, гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө ИНЕГ-0337/01 маягтын дагуу гаргаж ИНЕГ-т ирүүлнэ.

337.13 Аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалт

(а) ИНЕГ-аас нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ачаа тээвэр зуучлалын байгууллагад үзлэг шалгалт хийж болно.

(б) ИНЕГ нь үзлэг шалгалтанд шаардлагатай холбогдох бичиг баримт, мэдээллийг гэрчилгээ эзэмшигчээс шаардах эрхтэй.

Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**337.51 Ажилтан, албан тушаалтанд тавигдах шаардлага**

(а) Өргөдөл гаргагч дараах албан тушаалтан, ажилтантай байна:

- 1/ өргөдөл гаргагчийн зүгээс явуулж буй бүх үйл ажиллагаа энэ дүрмийн дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;
- 2/ энэ дүрмийн шаардлагыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэг хүлээсэн, ачаа тээвэрлэлтийн чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан.

(б) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 337.5-т заасан бичиг баримтыг боловсруулсан байх бөгөөд ажилтнуудынхаа боловсрол, мэргэжлийн ур чадварын түвшинг тодорхойлсон байна.

337.53 Хангалт, хэрэгсэл

(а) Өргөдөл гаргагч нь агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэртэй байхын зэрэгцээ үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ачааг тээвэрлэгчид хүргэх, хүлээн авах зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байна.

337.55 Бичиг баримт

(а) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 337.5-т заасан бичиг баримтыг боловсруулсан байна.

(б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д заагдсан бичиг баримтуудад хяналт тавих журамтай байна. Журамд дараах зүйлийг тусгасан байна:

- 1/ бичиг баримтууд, тэдгээрт оруулсан өөрчлөлтийг хэрхэн хянаж, баталгаажуулах талаар;
- 2/ хүчингүй болсон бичиг баримтыг ашиглалтаас хасах талаар.

337.57 Тайлан, мэдээ

(а) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааныхаа статистикийн мэдээллийг сар бүрийн дараа сарын 15-ны дотор гаргаж ИНЕГ-т ирүүлж байна.

337.59 Чанарын дотоод хяналтын систем

(а) Өргөдөл гаргагч нь энэ дүрмээр шаардсан журмууд хэрхэн мөрдөгдөж байгаа болон үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг бататгах зорилго бүхий байгууллагын чанарын дотоод хяналтын системтэй байна.

(б) Байгууллагын чанарын дотоод хяналтын систем нь дараах журмуудад үндэслэнэ:

- 1/ байгууллагын зорилго, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд чиглэсэн аюулгүй ажиллагааны заавар, журам;
- 2/ осол, дутагдлын бодит шалтгааныг тодорхойлох, шинжилгээ хийх журам;
- 3/ урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
- 4/ аудитын дотоод хөтөлбөр;
- 5/ удирдлага зохион байгуулалтын хяналтын журам.

(в) Аюулгүй ажиллагааны заавар журмууд нь ойлгомжтой, байгууллагын бүх түвшинд хэрэгжихүйц байна.

(г) Осол, дутагдлын бодит шалтгааныг тодорхойлох, шинжилгээ хийх журамд дараах зүйлүүд тусгагдсан байна:

- 1/ дутагдлыг хэрхэн арилгах талаар;
- 2/ дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд холбогдох журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;
- 3/ дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд үндэслэн удирдлага зохион байгуулалтын системээ хянах талаар;

(д) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах зүйлүүд тусгагдсан байна:

- 1/ үүсэж болзошгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар;
- 2/ урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд холбогдох журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;
- 3/ урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн удирдлага зохион байгуулалтын системээ хянах талаар.

(е) Аудитын дотоод хөтөлбөрт дараах зүйлүүд тусгагдсан байна:

- 1/ аудит хийгдэх объект, давтамжийн талаар;
- 2/ аудитыг хэн гүйцэтгэх тухай;
- 3/ шалгалтын дүнг хэрхэн мэдээлэх тухай;
- 4/ шалгалтаар дутагдал илэрсэн тохиолдолд түүнийг арилгах арга хэмжээний талаар;
- 5/ дутагдлыг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх, шалгалтын мөрөөр хийгдсэн ажлын үр дүнг хэрхэн хянах талаар;

(ж) Удирдлага зохион байгуулалтын хяналтын журамд:

- 1/ байгууллагын дотоод хяналтын системийн идэвхтэй ажиллагааг хангах үүднээс тухайн системийн удирдлага зохион байгуулалтад хяналт тавих үечлэлийг заасан байна;
- 2/ байгууллагын дотоод хяналтын системд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг тодорхойлсон байна.

(з) Байгууллагын дотоод хяналтын систем хариуцсан ажилтан нь аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй байна.

337.61 Байгууллагын зааварт тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг тусгасан зааврыг боловсруулж ИНЕГ-т ирүүлнэ:

- 1/ байгууллагын нэрийн өмнөөс ИНЕГ-тай шууд харьцах эрх бүхий удирдах албан тушаалтнуудын нэрс;
- 2/ байгууллагын бүтцийн зураглал;
- 3/ ачааны даатгалын төрөл;
- 4/ дараах журмууд:

- 4.1 энэ дүрмийн 337.51.-д тусгагдсан ажилтан, алба тушаалтны ур чадварыг үнэлэх, хадгалах журам;
- 4.2 энэ дүрмийн 337.55-ын (б)-д тусгагдсан бичиг баримтын ашиглалтын журам;
- 4.3 энэ дүрмийн 337.57-д тусгагдсан тайлан, мэдээг гаргаж журам;
- 4.5 энэ дүрмийн 337.59-ын (б)-д тусгагдсан, байгууллагын чанарын дотоод хяналтын журам;

5/ зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журам.

(б) Байгууллагын заавар нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

337.101 Гэрчилгээ эзэмшигчийн үндсэн үүрэг

(а) Гэрчилгээ эзэмшигч нь:

- 1/ зааврын хувийг байгууллагынхаа үндсэн байршил бүрт хадгална;
- 2/ зааварт тусгагдсан бүх журмуудыг мөрдөнө;
- 3/ шаардлагатай гэж үзвэл аливаа этгээдэд зааврын холбогдох заалтуудыг хувилж түгээсэн байна;
- 4/ энэ дүрмийн Бүлэг Б-д заасан шаардлагуудыг байнга дагаж мөрдөнө;
- 5/ байгууллагын нэр, хаяг, утас, факсны дугаар өөрчлөгдөх тохиолдолд ИНЕГ-т мэдэгдэнэ.

337.103 Байгууллагын зааварт өөрчлөлт оруулах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь заавартаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, тодорхойлолт хэвээр үлдэнэ гэдгийг бататгана.

(б) Зааварт оруулах нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлагад нийцсэн байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь зааварт орох нэмэлт, өөрчлөлтийг ИНЕГ-аар баталгаажуулна.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-аас нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах талаар гаргасан бичиг баримтад үндэслэн байгууллагын заавартаа нэмэлт өөрчлөлт оруулна.

Г БҮЛЭГ. АГААРААР АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТҮР ГЭРЧИЛГЭЭ

337.151 Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлага

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх түр гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ өргөдөлд заасан үйл ажиллагааг гүйцэтгэх, хянах мэргэшсэн ажилтнуудтай байх;
- 2/ ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх хөрөнгийн эх үүсвэртэй байх;
- 3/ ачааг даатгуулсан байх;
- 4/ ачааг агаарын тээвэрлэгчид хүргэх, хүлээн авах зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх;
- 5/ энэ дүрмийн 337.5.-т заасан бичиг баримтыг боловсруулсан ба тэдгээр нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн байх.

(б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д заасан шаардлагуудыг хангах, мөрдөх талаарх нарийвчилсан мэдээллийг ИНЕГ-т гаргаж өгнө.

337.153 Үндсэн үүрэг

(а) Агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх түр гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн 337.151-ын (а)-д заасан шаардлагыг тогтмол дагаж мөрдөнө.

337.155 Тайлан, мэдээ

(а) Агаараар, ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэх түр гэрчилгээ эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааны статистикийн мэдээллийг сар бүрийн дараа сарын 15-ны дотор гаргаж ИНЕГ-т ирүүлж байна.